




СОЁЛЫН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛЫН САЙД  
БОЛОН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН  
2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛЫН САЙД  
БОЛОН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН  
2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны ᠑᠘ дугаар  
сарын 1᠘-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, **Соёлын сайд Ч.Номин** /цаашид “Сайд” гэх/, нөгөө талаас Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат /цаашид “Засаг дарга” гэх/ нар Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18, 27 дугаар зүйлийн 27.5.8, Захиргааны ерөнхий хуулийн 52.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн соёл, урлагийн салбарт хамтран ажиллах, эрх үүрэг, хүрэх үр дүн, түүнийг үнэлэх, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ТАЛУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээгээр талууд Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль болон бусад соёлын салбарын хууль тогтоомжид заасан чиг үүрэг, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх зорилгоор дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.1.2. “Цахим соёл”, “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Сонгодог урлаг-III”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээний хэрэгжилтийг харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх;

2.1.3. “Монгол өв ба дэлхий дахин” олон улсын арга хэмжээний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх;

2.1.4. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог бий болгох, сайжруулах;

2.1.5. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулах;

2.1.6. Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг бий болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;

2.1.7. Соёлын үйл ажиллагааны санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэх;

2.1.8. Иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилсан соёлын өвийг хамгаалах үр ашигтай, тогтвортой механизм бүрдүүлж, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлэх;

2.1.9. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, эрчимжүүлэх.

2.2. Энэхүү гэрээний 2.1-д заасан нийтлэг чиг үүргийн хүрээнд соёл, урлагийн үйлчилгээний чиглэлээр хийх ажлыг 1 дүгээр хавсралт, соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийх ажлыг 2 дугаар хавсралт, урлаг, уран бүтээлийн үйлчилгээний чиглэлээр хийх ажлыг 3 дугаар хавсралт, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлээр хийх ажлыг 4 дүгээр хавсралт, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр 5 дугаар хавсралт, соёлын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хийх ажлыг 6 дугаар хавсралтаар баталж, хэрэгжүүлнэ. **Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.**

## ГУРАВ. СОЁЛЫН САЙДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний 2.1, 2.2-т заасан чиг үүрэг, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бодлогын удирдамж, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллана.

3.2. Энэхүү гэрээний хэрэгжилтийг хангахад Засаг даргад мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий соёл, урлаг хариуцсан нэгжийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.3. Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хүрээнд соёлын байгууллагуудын 2023 оны санхүүжилтийг олгох.

3.4. Энэхүү гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцна.

3.5. Энэхүү гэрээний хагас, бүтэн жилийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан хугацаанд хүргүүлнэ.

## ДӨРӨВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Энэхүү гэрээний 2.1, 2.2-т заасан чиг үүрэг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах, зохицуулах үйл ажиллагааг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эрхлэн гүйцэтгэнэ.

4.2. Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд соёлын өвийг хадгалж хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, иргэдэд соёлын боловсрол олгох, соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх

чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэмэлтээр тусгуулж, хэрэгжилтийг хангана.

4.3.Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд энэхүү гэрээний хавсралтад заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, хөрөнгө оруулалт, хүний нөөц, удирдлага зохион байгуулалтыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллана.

4.4.Аймгийн соёл, урлагийн байгууллагын удирдах албан тушаалтныг томилж, чөлөөлөхдөө Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, Соёлын сайдтай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлөх үүрэг хүлээнэ.

4.5.Орон нутгийн соёлын байгууллагад нэн шаардлагатай орон тоог бий болгох, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудлаар шийдвэр гаргахдаа Соёлын яамтай зөвшилцөх зарчим баримтална.

4.6.Засгийн газраас баталсан тогтоолын дагуу аймгийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

4.7.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18 дах заалтад заасны дагуу орон нутгийн өмчийн соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын асуудлыг хариуцаж, тодорхой хөрөнгийг зарцуулна.

4.8.Орон нутагт түүх, соёл, урлаг, эсхүл соёлын үнэт зүйлийг тодорхойлж, хот суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангана.

4.9.Соёл, урлагийн байгууллагыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, нэн шаардлагатай мэргэжлээр сургах, мэргэшүүлэх, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах талаар бүх талын дэмжлэг үзүүлнэ.

4.10.Соёл, урлагийн байгууллагыг түшиглэн хүүхэд багачуудын үндэсний хэл, соёл, уламжлал, зан заншлаас суралцах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр соёлын олон талт ажлыг зохион байгуулна.

4.11.Соёлын салбарын статистикийн мэдээ, тайланг хугацаанд нь үнэн, бодитой гаргаж ирүүлэх, тайланд өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулна.

4.12.Орон нутгийн өөрийн онцлогт нийцсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлж, брэнд болгон хөгжүүлнэ.

4.13.Соёл, урлагийн үндэсний хэмжээний эвент, арга хэмжээ, “Монголд зочлох жил” арга хэмжээний төлөвлөгөөг дэмжин хэрэгжүүлж ажиллах, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах соёл, урлагийн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөг гаргаж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

4.14. Соёл, урлагийн үйлчилгээнд баримтлах стандарт болон шинээр батлагдсан “Соёлын төв, соёлын ордны орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 6981:2022 стандартын хэрэгжилтийг ханган ажиллана.

4.15. Төсвийн жилийн дундуур соёлын байгууллагуудын орон тоо болон төсөв нэмэгдүүлэх ямар нэгэн шийдвэр гаргахгүй, гарсан тохиолдолд орон нутгийн төсвөөс санхүүжнэ.

#### ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

5.1.Орон нутаг өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг бүтэн жилээр тооцож, хэрэгжүүлнэ.

5.2.Монгол Улсын 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлж, техник, хяналт гүйцэтгэх үүргийг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу барилга угсралтын ажлын хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, тайлагнаж, холбогдох зардлыг шилжүүлнэ.

5.3.Шинээр 2024 онд төлөвлөх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, газрын зөвшөөрөл, батлагдсан зураг төсвийн саналыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний дотор [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) цахимаар болон цаасан хэлбэрээр ирүүлнэ.

#### ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ГЭРЭЭГ ДҮГНЭХ

6.1.Аймаг нь гэрээний биелэлт, соёл, урлагийн салбарын төсвийн тайлагналтын чиглэлээр дараах үүрэг хүлээнэ:

6.1.1.гэрээний биелэлтийг зүйл, заалт нэг бүрээр чанартай боловсруулан хагас жилийн тайланг 2023 оны 7 дугаар сарын 15-ны, бүтэн жилийн тайланг 12 дугаар сарын 25-ны дотор Соёлын яаманд ирүүлэх;

6.1.2.соёлын байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд орон нутгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан баталгаажуулсан байх;

6.1.3.төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах;

6.1.4.статистикийн мэдээлэл, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж, холбогдох газарт хүргүүлэх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж, ил тод байдлыг хэрэгжүүлэх;

6.1.5.аймгийн соёл, урлагийн салбарын барилга байгууламжийн бүртгэлийг жил бүр шинэчилж ашиглалт хамгаалалтын талаарх мэдээллийг Соёлын яаманд улирал бүр хүргүүлж байх;

6.1.6.хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, ажлын явц, үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчлах, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

6.1.7.Засаг даргаас улсын төсвийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн тайланг Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн 102 тушаалаар баталсан журмын маягтын дагуу гаргаж Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр болон цахим шуудангаар ирүүлэх.

ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛЫН  
САЙД

Ч.НОМИН




ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

Ц.МӨНХБАТ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн,  
Соёлын сайд болон Дундговь аймгийн  
Засаг дарга нарын 2023 онд хамтран  
ажиллах гэрээний нэгдүгээр хавсралт



ДУНДГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

№	Зорилтод арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх байгууллага		
							Үндсэн	Хамтран	Оролцогч
1.1	<b>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол 2.3</b> Соёл, урлагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Соёл, урлагийн байгууллагад менежментийн шинэчлэл хийгдсэнээр	МУЗГ-ын 2021 оны 377-р тогтоол	Соёл, урлагийн байгууллагын удирдлага зохион байгуулалтад менежментийн шинэчлэл хийгдсэн байна.	Засаг дарга	СУГ	СУБ
1.2	<b>Соёлын тухай хуулийн 39.1</b> Аймгийн Соёл, урлагийн газрын бүтцэд соёлын байцаагчийн орон тоог бий болгох, ажиллах нөхцлөөр хангах	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Улсын байцаагчтай болсон байх	Баян-Өлгий, Хөвсгөл, Дорноговь, Дорнод	Соёлын улсын байцаагчтай болсон байна.	Соёлын сайд Засаг дарга	СУГ	
1.3	<b>Шинэ сэргэлтийн бодлого 4.2</b> Соёл, урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих;	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Орон нутагт шилжин суурьшихад орон сууц, бусад дэмжлэг Сургалт, сурталчилгаа	-	Орон нутгийн соёлын байгууллагад хотоос шилжин суурьших иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна.	Засаг дарга	СУГ	СУБ Холбогдох байгууллага, аж ахуй нэгж
1.4	<b>"Алсын хараа 2050" 1.2.2, Соёлын тухай хууль 24.1.1, 30.1, 30.2, 30.3</b> Соёлын үнэт зүйлсийг судлан, соёлын орчин, орон зай, брэндийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх;	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Соёлын орон зай, бүтээгдэхүүн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулсан эсэх	-	Соёлын нөөц, орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байна.	Засаг дарга	СУГ БОАЖГ	СУБ Холбогдох байгууллага, аж ахуй нэгж

1.5	<b>Соёлын тухай хуулийн 24.1.2</b> Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар дэмжлэг үзүүлэх;	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах Ажилтны нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн байдал	-	Мэргэжлийн хүний нөөцийг өмнөх оноос 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна. Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.	Засаг дарга	СУГ	СУБ
1.6	<b>Соёлын тухай хуулийн 18.3, 18.6, 18.7</b> Шинээр батлагдсан "Соёлын төв, соёлын ордны орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 6981 : 2022 стандартад улсын хэмжээний тандалт судалгаа, эрсдлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Стандартын хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн тоо	-	Стандартын шаардлага хангасан соёлын төв, ордны тоо нэмэгдсэн байна.	Засаг дарга	СУГ	СУБ
1.7	<b>Соёлын тухай хууль 37.9, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.16, 22.1.17</b> Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлэн зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	6-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Засаг дарга	СУГ	СУБ
1.8	<b>Соёлын тухай хууль 37.9</b> Хүний эрх, хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Засаг дарга	СУГ	СУБ
1.9	<b>Соёлын тухай хууль 39.5</b> Хүчирхийлэл, дайн түрэмгийлэл, гэмт хэрэг, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Урьдчилан сэргийлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан авсан байна.	Засаг дарга	СУГ	СУБ

---00---



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

№	Зорилтод арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх байгууллага		
							Үндсэн	Хамтран	Оролцогч
2.1	<p><b>Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</b></p> <p>Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор соёлын боловсрол олгох олон талт ажлыг хүүхэд, гэр бүл рүү чиглүүлэх, иргэдийн хамтдаа амьдрах соёл, ахуйн соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн аяныг зохион байгуулж, тухайн орон нутгийн бүх шатны байгууллага, хувийн хэвшил, ТББ, иргэдийг уриалах</p>	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Тодорхойлох шаардлагатай	Тухайн аймгийн иргэдийн соёлын боловсролын суурь түвшнийг тодорхойлох судалгаа хийгдэж, зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээний тоо нэмэгдсэн байна.	Засаг дарга	ЗГХА-СУГ, Аймгийн СУГ, Соёл, урлагийн байгууллага	Соёл урлагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд
2.2	<p><b>Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</b></p> <p>Соёл, урлагийн байгууллагууд соёлын боловсролын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	I, II, III, IV улиралд	Улсын болон орон нутгийн төсөв	Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо	-	Соёлын боловсрол олгох хөтөлбөрийн тоо нэмэгдсэн байна.	Засаг дарга	Аймгийн СУГ	Соёл урлагийн байгууллага
2.3	<p><b>Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</b></p> <p>Нүүдлийн ахуй, үндэсний өв, соёл, уламжлалыг сурталчлан таниулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</p>	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Нүүдлийн ахуй соёлыг таниулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Нүүдлийн ахуй, үндэсний өв, соёл, уламжлалыг сурталчлан таниулах үйл ажиллагаа, хамрагдагчдын тоо нэмэгдсэн байна.	Засаг дарга	Аймаг, нийслэлийн СУГ	Соёл урлагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хүүхэд

2.4	Соёлын тухай хуулийн 9.1.4, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 1.4. Эрдэм судлалын ажлыг удирдан зохион байгуулах	I, II, III, IV улирал	орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хамрагдсан хүний тоо	-	Шинээр хэвлэгдсэн ном, зохиол, судалгааны шинжилгээний бүтээлийг сурталчлах таниулах арга хэмжээг улирал тутам зохион байгуулсан байна.	Засаг дарга	Аймгийн СУГ, нийтийн номын сан	Соёл урлагийн байгууллага, бүх шатны сургалтын байгууллага, нийтийн номын сан
2.5	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын 2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг Орон нутагт "Номын баяр - 2023" арга хэмжээг зохион байгуулах болон номын санд сан хөмрөгийн баяжилт хийхэд дэмжлэг үзүүлэх	I, II, III, IV улиралд	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо, баяжилт хийгдсэн номын тоо	Номын баяр 2021	Номын санг түшиглэн "Номын баяр" арга хэмжээний хүрээнд уншлагыг дэмжих соёлын олон талт ажлыг зохион байгуулж, номын сангийн сан хөмрөг нэмэгдэж, номын сангаар үйлчлүүлсэн уншигчийн тоог нэмэгдүүлсэн байна.	Засаг дарга	ЗГХА-СУГ, Аймгийн СУГ	Аймгийн нийтийн номын сан, Сумын соёлын төв
2.6	Соёлын тухай хуулийн 24.1.1, 25 дугаар зүйл, Соёлын төв, ордныг түшиглэсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлж, брэнд болгон хөгжүүлэх	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Брэнд бүтээгдэхүүнтэй сумдын тоо	Тодорхойлох шаардлагатай	Брэнд бүтээгдэхүүнтэй сумдын тоо нэмэгдэж, соёлын төвийг түшиглэсэн аялал жуулчлал хөгжиж эхэлсэн байна.	Засаг дарга	Сумын Засаг дарга	Соёлын төв, ордон
2.7	Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол хэлний тухай хуулийн 7.2, 14.1.1, 17 дугаар зүйл, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" 3.2.15. Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлах, монгол бичгээр дагнасан үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах, "Бүх нийтээрээ хос бичигтэн" болоход уриалсан нөлөөллийн ажлууд зохион байгуулах	I, II, III, IV улиралд	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ, нөлөөллийн ажлын тоо	1. Тухайн бүс нутагт буй бичиг үсгийн дурсгалд холбогдох баримтат өвийн бүртгэл; 2. "Үндэсний бичиг үсгийн баяр-2023", "Эх хэлний өдөр-2023" арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан	Үндэсний бичиг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна.	Засаг дарга	ЗГХА-СУГ, Аймгийн СУГ, Соёлын төв	Соёл урлагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд

2.8	<p>Соёлын тухай хуулийн 22.1.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 16.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.6.2.2</p> <p>Хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх</p>	I, II, III, IV улирал	Орон нутгийн төсөв	Хуулийн хэрэгжилт хангагдаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн эсэх.	СӨБ-ын хүүхдэд зориулсан зохиол бүтээлийн цахим сан байгуулж, үг хэллэгийн бүртгэл гарсан.	Судалгаа -1, санал, зөвлөмж-1	Засаг дарга	ЗГХА-СУГ	Соёл урлагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага
-----	---	-----------------------	--------------------	---	--	-------------------------------	-------------	----------	--

---000---

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд  
болон Дундговь аймгийн Засаг дарга нарын 2023 онд  
хамтран ажиллах гэрээний гуравдугаар хавсралт

УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ДУНДГОВЬ АЙМАГТ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

№	Зорилтод арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх байгууллага		
							Үндсэн	Хамтран	Оролцогч
3.1	<b>Соёлын тухай хуулийн 21.1.3, 21.1.8, 21.1.7, 21.1.11 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.3</b> Орон нутгийн угсаатан, ястны онцлог бүхий сонгодог, орчин үеийн уран бүтээл туурвин, алслагдсан сумын иргэд, хүүхэд, залуучуудад хүргэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх	I - IV улирал	Улсын болон орон нутгийн төсөв	Уран бүтээлийн тоо, Үзэгчдийн тоо	-	1-ээс доошгүй шинэ уран бүтээл туурвиж, Орон нутгийн хүн амын 25-аас доошгүй хувьд хүргэсэн байна.	Театр, чуулга	Аймгийн ЗДТГ	Соёл, урлагийн газар
3.2	<b>Соёлын тухай хуулийн 21.1.11. Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 6 дугаар зорилт</b> Урлаг, уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэх, үндэсний агуулгатай контентыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхэд дэмжлэг үзүүлэх.	I - IV улирал	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	-	3-аас доошгүй арга хэмжээг дэмжсэн байна.	Аймгийн ЗДТГ	Аймгийн СУГ	Иргэн, хуулийн этгээд
3.3	<b>Соёлын тухай хуулийн 21.1.11. Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 6 дугаар зорилт</b> Олон улсын болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд театр, чуулга, мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг оролцуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, өргөнөөр хамруулах	IV улирал	Орон нутгийн төсөв	Оролцогчдын тоо	-	5-аас доошгүй уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг дэмжсэн байна	Аймгийн ЗДТГ	Аймгийн СУГ, театр, чуулга	Уран бүтээлчид, хүүхэд залуучууд
3.4	<b>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.3</b> Кино, дуу, хөгжим, дүрслэх, дизайн болон бусад тайзны урлагийн төрлийг хамруулсан урлагийн боловсролын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	I - IV улирал	Улсын болон орон нутгийн төсөв	Сургалт зохион байгуулагдсан эсэх	-	Урлагийн чиглэл бүрээр 4-с доошгүй сургалт, арга хэмжээ сургалт зохион байгуулагдсан байна.	Аймгийн ЗДТГ	Аймгийн СУГ,	Иргэн, хуулийн этгээд
3.5	<b>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1.</b> Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээг нэгдсэн өнгө төрх, агуулгад нийцүүлэн зохион байгуулах	III улирал	Орон нутгийн төсөв	нэгдсэн өнгө төрхтэй зохион байгуулагдсан эсэх	-	улсын хэмжээнд нэгдсэн өнгө төрх, агуулгад нийцүүлэн зохион байгуулсан байна.	Аймгийн ЗДТГ	Аймгийн СУГ	Театр, чуулгын уран бүтээлчид